

## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийгмийн даатгалын 5 сангуудаас тэтгэмжийн болон эрүүл мэндийн даатгалын сангуудын зарцуулалтын баримтжуулалт, дотоод хяналт зэрэг нь хангалтгүй байна.

Эрүүл  
мэнд,  
нийгмийн  
даатгалын  
сангуудын  
2016 оны  
үйл  
ажиллагаа

2018 он

Гүйцэтгэсэн:

Аудитор  
Г.Заяа  
Аудитор  
Г.Чулуунбаатар

**Хянасан:**

Тэргүүлэх аудитор  
Л.Уламбаяр

Аудитын менежер  
Г.Хашцэцэг

2018.06.10

Уг тайланг [WWW.AUDIT.MN](http://WWW.AUDIT.MN) сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99019467, 99058189 утсаар харилцана уу.

ХАЯГ: Завхан аймаг дахь Төрийн Аудитын газар  
Улиастай сум, Жинст баг  
НЗО-ны 309, 310 тоот

## **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Монгол улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, аймгийн ИТХ-аас ирүүлсэн захиалгын дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймаг дахь Төрийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

## **Аудитын зорилт**

Нийгмийн даатгалын сангуудын 2016 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүн сэдэвт аудитыг хийхдээ дараахь зорилтыг дэвшүүлсэн.

- Нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн зарцуулалт бодитой байна уу?
- Шинээр тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох үйл ажиллагаа нь холбогдох хууль, журамд нийцэж байна уу?
- Нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт үр дүнтэй байна уу?

## **Хамарсан хүрээ**

2016 оны нийгмийн даатгалын 5 сангийн санхүүгийн үйл ажиллагааг аймаг, сумдын түвшинд түүвэрчлэн шалгалаа.

## **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох албан тушаалтан нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Уламбаяр, аудитын менежер Г.Хашцэцэг нар хянан удирдаж, аудитор Г.Заяа багийг ахлан, аудитор Г.Чулуунбаатарын хамт 2018 оны 04 дүгээр сарын 10-наас 2018 оны 06 дугаар сарын 10-ний хооронд гүйцэтгэлээ.

## **Ерөнхий мэдээлэл:**

2016 онд тэтгэврийн даатгалын сангаас 30366,6 сая төгрөгийн тэтгэврийг 10653 даатгуулагчид олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 1817 иргэнд 1248,5 сая төгрөгийн тэтгэмжийг, ажилгүйдлийн даатгалын сангаас 362 иргэнд 362,7 сая төгрөгийн тэтгэмжийг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 15 иргэнд 43,2 сая төгрөгийн тэтгэврийг олгосон.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн үйлчилгээний зардалд 2535,9 сая төгрөгийг, сувиллын үйлчилгээний зардалд 119,0 сая төгрөгийг, эмийн зардалд 429,4 сая төгрөгийг хуваарилан олгожээ.

**Бүлэг 1. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт бодитой байгаа ч эрүүл мэндийн даатгалын сангуудын баримтжуулалт хангалтгүй байна.**

### **1.1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сангуудын зарцуулалт бодитой байна.**

2016 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 7 сумын 15 тэтгэвэр авагчдад 43.1 сая төгрөгийн тэтгэвэр олгосныг тэтгэвэр авагчийн массивтай тулган шалгахад зөрчил илрээгүй.

2016 онд 427,3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгохоор тооцсоноос 362,7 сая төгрөгийг олгон, үлдэгдэл 64,6 сая төгрөгийн тэтгэмжийг өглөгөөр бүртгээгүй байгаа нь даатгуулагчид ажилд орж тэтгэмж нь зогсоогддогтой холбоотой байна. Нөгөө талаар ажилгүйдлийн программаас даатгуулагч бүрийн мэдээллийг харах боломжтой ч ажилгүйдлийн тэтгэмжийг тайлант хугацаагаар ангилж, зогсоогдсон тэтгэмжийг ялгах боломжгүй байгааг анхааран НДЕГ-т уг программыг сайжруулах хүсэлт тавин шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Ажилгүйдлийн тэтгэмж нь 273,7 сая төгрөгийн төсөвтэй байхад даатгуулагчдын тоо өссөнөөс шалтгаалан 362,7 сая төгрөгийн тэтгэмж олгосон бөгөөд 89,0 сая төгрөгийн дутагдсан эх үүсвэрийг НДЕГ-аас нэмэлт санхүүжилт аван санхүүжүүлжээ.

### **1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын баримтжуулалт хангалтгүй байна.**

2016 онд нэр бүхий 5 эмнэлэг, 2 сувиллын газар нь 77472 даатгуулагчийн тусламж үйлчилгээний зардал 2817,2 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилснийг аймгийн НДХ-ээс хянан 57673 даатгуулагчийн 2654,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Эмнэлгүүдэд олгосон санхүүжилтийг аймгийн НДХ-ээс хянасан дүн, эмнэлгүүдээс ирүүлсэн нэхэмжлэлтэй тулган шалгахад Отгонтэнгэр рашаан сувиллын 2,8 сая төгрөгийн сувиллын зардлын нэхэмжлэх дутагдсан, 13,7 сая төгрөгийн зардлыг хянасан тооцооны хуудсыг хавсаргаагүй зөрчил илэрлээ.

Тайлант онд 41 эмийн сан нь 26314 даатгуулагчийн эмийн үнийн хөнгөлөлтөнд 436,9 сая төгрөг нэхэмжилснийг аймгийн НДХ-ээс хянан 25824 даатгуулагчийн 429,4 сая төгрөгийн хөнгөлөлтийг олгосон байна. Эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилтийн баримтыг шалгахад Сод овоот эмийн сангийн 0,2 сая төгрөгийн нэхэмжлэх, хянасан тооцооны хуудасны хамт дутагдсан, Гал чацаргана, Аньс эмийн сангуудад олгосон санхүүжилтийг 0,4 сая төгрөгөөр зөрүүтэй

тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн баримтжуулалтыг шалгахад байцаагч эмч нь тусламж үйлчилгээний чанарыг хянаж, холбогдох маягтыг нөхөөгүй, гадны даатгуулагчдын хяналтын хуудас, илрүүлсэн зөрчлийн бүртгэлийн хуудсыг хавсаргаагүй дутагдал нийтлэг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 2016 оны батлагдсан төсөвтэй тулган шалгахад 57,6 сая төгрөгөөр дутуу зарлага гаргасан нь тусламж үйлчилгээ хүртэгсдийн тоо цөөн, төлөвлөлт бодитой бус байгаатай холбоотой байна.

Бодит гүйцэтгэлээс Отгонтэнгэр рашаан сувиллын төлөвлөлт 21,3 сая төгрөгөөр, Аньс эмийн сангийн төлөвлөлт 26,0 сая төгрөгөөр, Сантмаргац сумын эмийн сангийн төлөвлөлт 1,0 сая төгрөгөөр, Завханмандал сумын эмийн сангийн төлөвлөлт 0,5 сая төгрөгөөр, Тэс сумын эмийн сангийн төлөвлөлт 1,1 сая төгрөгөөр, Сод овоот эмийн сангийн төлөвлөлт 2,2 сая төгрөгөөр, Гал чацаргана эмийн сангийн төлөвлөлт 0,5 сая төгрөгөөр, Түдэвтэй, Ургамал сумдын эмийн сангуудын төлөвлөлт 1,2 сая төгрөгөөр тус тус илүү байна.

***Иймд Отгонтэнгэр рашаан сувилал, Аньс эмийн сан, зарим сумдын эмийн сангуудын төлөвлөлт бодитой бус байгаа асуудлыг НДЕГ-т тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.***

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт, түүний анхан шатны баримтын бүрдүүлэлт, төлбөр авч буй үндэслэлийг эмнэлэг, эмийн сан бүрээр шалгахад дараахь зөрчлүүд илэрлээ.

- ✓ Эрүүл мэндийн даатгалын байцаагч эмч, зардал хариуцсан байцаагч, хэлтсийн дарга нарын нэхэмжлэлд тавих хяналт хангалтгүйгээс Уламжлалт анагаах ухааны төв, Одчим наран, Тосонцэнгэл сумын эмнэлэг зэрэг газруудад 0,5 сая төгрөгийн санхүүжилт илүү олгогдсон. Илүү олгогдсон санхүүжилт нь өвчний оношийн кодыг буруу нэхэмжилсэн, даатгуулагчийн нэрийг давхардуулсан зэрэгтэй холбоотой байна.
- ✓ Баянхайрхан, Ургамал сумдын эмийн сангууд, Тунгийн увидас, эмийн санд 0,4 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийг илүү тооцож олгосон.
- ✓ Түдэвтэй сумын сум дундын эмнэлэг нь аймгийн НДХ-тэй хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний гэрээ байгуулсан мөртлөө зөвхөн мэс заслын тасгийн даатгуулагчдаа нэхэмжилдэг зөрчил илэрсэн.
- ✓ Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 10 даатгуулагчийн 2,9 сая төгрөгийн санхүүжилттэй өвчний түүх, Түдэвтэй сумын сум дундын эмнэлэг нь 14 даатгуулагчийн 3,7 сая төгрөгийн санхүүжилттэй өвчний түүхийг дутагдуулсан зөрчил гаргасан тул тухайн байгууллагуудад зөрчлийг таслан зогсоож, холбогдох мэргэжилтнүүдэд хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүллээ.
- ✓ Тусламж үйлчилгээний зардлын болон эмийн үнийн хөнгөлөлтийн

санхүүжилтийг олгоходоо даатгуулагчдын үйлчилгээний давтамж илрүүлдэг, санхүүжилт олгодог программуудыг ашигладаг боловч эдгээр программын уялдаа холбоо шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

### **1.3. Тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын сангийн зарцуулалт бодитой байна.**

Тайлант онд тэтгэмжийн даатгалын сангаас 652 даатгуулагчид 907,3 сая төгрөгийн жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг, 355 даатгуулагчид 294,2 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг, 478 даатгуулагчид 46,9 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг батлагдсан төсөвтөө багтаан олгожээ.

Аудитаар тэтгэмжийн байцаагчийн хянасан тэтгэмжийн дүн санхүүгийн тайланд тусгагдсан тэтгэмжээс 1,0 сая төгрөгөөр зөрсөн нь 1 даатгуулагчийн мэдээлэл программаас утсантай холбоотой байна.

Асгат сумын нийгмийн даатгалын байцаагч 1 даатгуулагчид 0,09 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг аймгийн НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагчаар хянуулалгүй олгосон зөрчил илэрлээ.

2016 онд тэтгэврийн даатгалын сангаас 10,653 тэтгэвэр авагчдад 30,366.6 сая төгрөгийн тэтгэврийг батлагдсан төсөвтөө багтаан олгосон байна.

Тэтгэвэр тогтоолтын массивыг тэтгэвэр олголтын жагсаалттай тулган шалгахад 0,6 сая төгрөг дутагдсан бөгөөд энэ зөрчлийг тайлант оны дотоод хяналтаар илрүүлэн нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2016.11.16-ны өдрийн 38, 2016.11.20-ны өдрийн 43 тоот актуудаар нөхөн төлүүлсэн байна.

**Бүлэг 2. Шинээр тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох үйл ажиллагаа нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа ч тэтгэмж олголтын баримтжуулалт шаардлага хангаагүй байна.**

### **2.1. Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын үйл ажиллагаа нь холбогдох хууль, журамд нийцэж байгаа ч тэтгэмж олголтын баримтжуулалт шаардлага хангаагүй байна.**

Тэтгэмжийн даатгалын сангаас тайлант онд шинээр олгосон тэтгэмжийн тогтоолт, олголтыг шалгахад хууль журамд нийцэж байгаа ч баримтжуулалтын хувьд доорх зөрчлүүд илэрлээ.

- ✓ НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нь жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудасны тэтгэмж олголт хэсгийг бүрэн нөхдөггүй, аж ахуйн нэгж, байгууллагуудын нягтлан бодогчид жирэмсний чөлөө авахаас өмнөх 12 сарын хөдөлмөрийн хөлсийг үнэн зөв хөтлөөгүйгээс шалтгаалан 127 даатгуулагчийн нэхэмжилсэн тэтгэмж, аймгийн НДХ-ийн хянасан тэтгэмжээс 7,9 сая төгрөгөөр зөрүүтэй байсан. Аймгийн НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нь даатгуулагчийн хөдөлмөрийн хөлсний хэмжээг хянаснаа баримтжуулаагүй

- ✓ Аудитаар 59 даатгуулагчийн жирэмсэн, амаржсаны хугацаа давхардсан нь эмнэлгийн байгууллагууд эмнэлгийн хуудсыг олгохдоо хуулийн хугацааг баримталдаггүй, аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогчид тэтгэмжтэй цалинг давхардуулан олгодог, аймгийн НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нарын жирэмсний тэтгэмж олгох хугацаанд тавих хяналт хангалтгүй байгаа зэргийг харуулж байна. НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нь хугацаа хэтэрсэн эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгохдоо “хүндэтгэн үзэх шалтгаантай” гэсэн сонголтыг сонгосон шалтгаанаа баримтжуулаагүй
- ✓ Аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогчид, сумдын нийгмийн даатгалын байцаагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хуулийн дагуу тооцдоггүй, хувь хэмжээг буруу тооцдог, НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн тэтгэмж олголт хэсгийг бүрэн нөхдөггүй зэргээс шалтгаалан 283 даатгуулагчийн нэхэмжилсэн тэтгэмж, аймгийн НДХ-ийн хянасан тэтгэмжээс 4,0 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Аудитаар сумдын байцаагч нар жирэмсэн, амаржсаны, оршуулгын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжүүдийг хянадаггүй, баримтыг бүрдүүлэн аймгийн НДХ рүү явуулдгаас шалтгаалан нягтлан бодогчдын алдаа залруулагдаагүй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас Тосонцэнгэл, Улиастай сумдад шинээр тэтгэвэр тогтоолгосон 356 тэтгэвэр авагчдын хувийн хэргийн бүрдэл, тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгахад зөрчил илрээгүй.

Хүснэгтээр харуулбал:

Д/Д	Сумын нэр	Төрөл	Тэтгэвэр авагчийн тоо
1	Тосонцэнгэл	Өндөр нас	79
2	Тосонцэнгэл	Тахир дутуу	45
3	Тосонцэнгэл	Тэжээгчээ алдсан	6
4	Улиастай	Өндөр нас	140
5	Улиастай	Тахир дутуу	73
6	Улиастай	Тэжээгчээ алдсан	13
<b>Дүн</b>			<b>356</b>

Ажилгүйдлийн даатгалын сангаас Тосонцэнгэл, Улиастай сумдад олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагч бүрийн хувийн хэрэгтэй тулган шалгасан.

Хувийн хэргийг тулган шалгахад 9 даатгуулагчид 1,1 сая төгрөгийн тэтгэмжийг илүү олгосонд төлбөрийн акт тогтоон, 6 даатгуулагчид 0,4 сая төгрөгийн тэтгэмжийг дутуу олгосон зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө.

Эдгээр зөрчлүүд нь нийгмийн даатгалын сангийн ашиглаж байгаа программд даатгуулагчийн мэдээллийг оруулахдаа бүх нийтээр амрах амралтын өдрийг хасч тооцож оруулаагүйгээс зөрүүтэй олгогдсон байна.

Дээрх байдлаас дүгнэхэд аймгийн 24 сумаас хүн ам олонтой 2 сумыг сонгон тулгалт хийхэд 1,5 сая төгрөгийн зөрчил илэрч байгаа нь нийт сумдыг хамруулан үзвэл зөрчлийн хэмжээ өсөх магадлалтай байна гэж үзлээ.

Тайлант онд 362 даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаж, өмнөх оноос 175 даатгуулагчаар өссөнөөс шалтгаалан тэтгэмжийн дүн 162.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 1 даатгуулагчид 0,04 сая төгрөгийн тэтгэмж олгохоор тооцсоныг тайлант онд олгоогүй өглөгөөр бүртгэсэн байна.

**Бүлэг 3. Тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангуудын зарцуулалтанд хяналт тавьсан, харин тэтгэмжийн, эрүүл мэндийн даатгалын сангуудын зарцуулалтанд хяналт тавиагүй байна.**

**3.1. Тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалтанд хяналт тавьсан, харин тэтгэмжийн даатгалын санд хяналт тавиагүй байна.**

Тайлант оны тэтгэмжийн даатгалын сангийн зарцуулалтанд НДХ-ийн хяналтын байцаагч хяналт тавиагүй байна.

Аудитын явцад хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийн тогтоолт, олголтыг зөв тооцож байгаа эсэхэд дүгнэлт өгөхийн тулд сумдаас судалгаа авахад Асгат, Идэр, Их-Уул, Нөмрөг, Сонгино, Түдэвтэй, Тэлмэн, Тэс, Цагаанчулуут, Эрдэнэхайрхан, Яруу сумдын байцаагч нар судалгааг алдаатай ирүүлсэн. Эндээс дүгнэхэд сумдын нийгмийн даатгалын байцаагч нарыг чадавхижуулах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Тэтгэврийн болон ажилгүйдлийн сангийн 2016 оны үйл ажиллагаанд аймгийн НДХ-ийн дотоод хяналтаар 20 сумыг хамруулсан хяналт шалгалт хийн 2016 онд 15.9 сая төгрөгийн, 2017 онд 3.5 сая төгрөгийн төлбөрийг актуудыг тогтоон барагдуулсан байна.

Ажилгүйдлийн даатгалын санд ашиглаж байгаа программд даатгуулагчийн мэдээллийг оруулахдаа бүх нийтээр амрах амралтын өдрийг хасч тооцож оруулаагүйгээс ажилгүйдлийн тэтгэмж зөрүүтэй олгогдсон алдааг аймгийн НДХ-ийн дотоод хяналтаар илрүүлээгүй байна.

**3.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтанд тавих хяналт үр дүн муутай байна.**

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгохдоо 6 байгууллагын 244,4 сая төгрөгийн нэхэмжлэлийг хяналгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон зөрчил илэрснийг цаашид таслан зогсоох шаардлагатай байна.

Түүнчлэн эмнэлэг, эмийн сангуудаас ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж баталгаажуулах үйл явц шаардлагын хэмжээнд хүрээгүй, олгосон санхүүжилтийн 70-80 хувьд нь эрүүл мэндийн даатгалын байцаагч эмч хяналт тавьж холбогдох

маягтыг хөтлөөгүй байхад хэлтсийн дарга хяналтын хуудсыг баталгаажуулсан зөрчил нийтлэг байна.

Эмийн сангууд, эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанарт тавих хяналт шаардлагын түвшинд хүрээгүй байгаа нь хяналтын хуудсыг бүрэн нөхөөгүй байдал, өвчтний түүх дутагдсан, оношийн зөрүү гарч байгаа зэргээс харагдаж байна. Нөгөө талаар эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтанд хяналт тавих үүрэг бүхий ажилтнууд өөр ажил давхар хариуцан, ажлын ачаалал ихтэй ажилладгаас шалтгаалжээ.

Эмнэлгүүдийн өвчтөний түүх, нэхэмжлэлийг шалгах явцад зарим эмнэлэг өөрийн орлогоо дутуу төвлөрүүлсэн, өөрийн эмнэлэгтээ ажилтнуудаа хэвтүүлэн эмчилсэн боловч цалинг нь бүрэн олгосон зөрчлийг илрүүлэн, давтан гаргахгүйн тулд удирдлагуудад нь зөвлөмж хүргүүлжээ.

Аудитаар 2,1 сая төгрөгийн төлбөр тогтоогдон, 267,5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн нотлох зүйлсэд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн баримтжуулалт хангалтгүй. Тухайлбал: тусламж үйлчилгээний чанарын хяналтыг эмч, байцаагч шаардлагын хэмжээнд хийж, холбогдох маягтыг нөхөөгүй, гадны даатгуулагчдын хяналтын хуудас, илрүүлсэн зөрчлийн бүртгэлийн хуудсыг хавсаргаагүй
2. Аймгийн НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нь жирэмсэн, амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн эмнэлгийн хуудасны тэтгэмж олголт хэсгийг бүрэн нөхөөгүй
3. Аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогчид жирэмсний чөлөө авахаас өмнөх 12 сарын хөдөлмөрийн хөлсийг үнэн зөв хөтлөөгүйгээс шалтгаалан 127 даатгуулагчийн нэхэмжилсэн тэтгэмж, НДХ-ийн хянасан тэтгэмжээс 7,9 сая төгрөгөөр зөрсөн. Мөн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хуулийн дагуу тооцдоггүй, хувь хэмжээг буруу тооцдог зэргээс шалтгаалан 283 даатгуулагчийн нэхэмжилсэн тэтгэмж, НДХ-ийн хянасан тэтгэмжээс 4,0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
4. 59 даатгуулагчийн жирэмсэн, амаржсаны хугацаа давхардсан нь эмнэлгийн байгууллагууд эмнэлгийн хуудсыг олгохдоо хуулийн хугацааг баримталдаггүй, аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогчид тэтгэмжтэй цалинг давхардуулан олгодог, НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагч нарын жирэмсний тэтгэмж олгох хугацаанд тавих хяналт хангалтгүй байна.
5. Тэтгэврийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн зарцуулалтанд аймгийн НДХ-ийн хяналтын байцаагч хяналт тавьсан боловч тэтгэмжийн даатгалын сангийн зарцуулалтанд хяналт тавиагүй байна.
6. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгохдоо 6 байгууллагын 244,4 сая төгрөгийн нэхэмжлэлийг хяналгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон, хэлтсийн даргын хяналт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.
7. Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалт бодитой байна.
8. Ажилгүйдлийн даатгалын санд ашиглаж байгаа программ даатгуулагчийн мэдээллийг оруулахдаа бүх нийтээр амрах амралтын өдрийг хасч тооцож оруулаагүйгээс ажилгүйдлийн тэтгэмжийг зөрүүтэй тооцож байна.
9. Эмнэлэг, эмийн сангуудаас ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж баталгаажуулах үйл явц шаардлагын хэмжээнд хүрээгүй, олгосон санхүүжилтийн 70-80 хувьд нь эрүүл мэндийн даатгалын байцаагч эмч

хяналт тавиагүй, тусламж үйлчилгээний чанарын хяналтаар илрүүлсэн зөрчлийн бүртгэлийг хөтлөөгүй байхад хэлтсийн дарга хяналтын хуудсыг баталгаажуулсан зөрчил нийтлэг байна

- 10.Түдэвтэй сумын сум дундын эмнэлэг нь аймгийн НДХ-тэй хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний гэрээ байгуулсан мөртлөө зөвхөн мэс заслын тасгийн даатгуулагчдаа нэхэмжилдэг зөрчил илэрсэн.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

**Нийгмийн даатгалын 5 сангуудаас тэтгэмжийн болон эрүүл мэндийн даатгалын сангуудын зарцуулалтын баримтжуулалт, дотоод хяналт зэрэг нь хангалтгүй байна.**

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**

### **Аймгийн НДХ-ийн дарга Ш.Мянганбаярт**

1. НДХ-ийн тэтгэмж хариуцсан байцаагчид жирэмсэн, амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн эмнэлгийн хуудасны тэтгэмж олголт хэсгийг бүрэн нөхөх, хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаа хоцроосон болон жирэмсэн амаржсаны хугацаа давхардсан тохиолдолд баримтжуулж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцож ажиллах,
2. Сумдын нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч нарт чадавхижуулах сургалт зохион байгуулах, сумдын байцаагч нарт сумандаа тэтгэмжийн нэхэмжлэлийг хянан, нягтлан бодогчдын алдааг залруулж байх үүргийг хүргүүлэн хэрэгжүүлэх
3. Тэтгэмжийн даатгалын санд тавих дотоодын хяналтыг сайжруулах, тэтгэмжийн байцаагч хянаагүй байхад тэтгэмж олгодог зөрчлийг таслан зогсоох
4. Ажилгүйдлийн даатгалын санд ашиглаж байгаа программыг сайжруулах хүсэлтийг НДЕГ-т тавьж шийдвэрлүүлэх
5. Аудитаар тогтоогдсон төлбөр, зөрчлийг хугацаанд нь барагдуулах

### **Эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга Д.Цэндсүрэнд**

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн баримтжуулалтыг сайжруулах, тусламж үйлчилгээний чанарын хяналтын үр дүнг тооцож, холбогдох маягыг бүрэн нөхөж баримтжуулсны дараа тасгийн дарга баталгаажуулж хэвших,
2. Эмнэлэг, эмийн сангуудын тусламж үйлчилгээний чанарт тавих эрүүл мэндийн даатгалын байцаагч эмчийн хяналтыг сайжруулах
3. Өвчтний түүхийг хүлээж авах, буцаан олгох үйл явцыг баримтжуулах
4. Түдэвтэй сумын сум дундын эмнэлэгтэй байгуулсан гэрээг хэрэгжүүлэн, тус эмнэлгийн дотор, хүүхэд, мэдрэлийн тасагт хэвтэн эмчлүүлэгсдийн тусламж үйлчилгээний зардлыг олгож хэвших

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

## АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....	1
Ерөнхий мэдээлэл .....	2
ОНӨААТҮГ нь орлого, зардлаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу .....	2-8
ОНӨААТҮГ нь бүтэц, орон тоогоо оновчтой зохион байгуулан дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэр зэрэг биелүүлсэн бэ .....	9-11
Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, арвилан хэмнэлт үр нөлөөтэй байна уу .....	12-13
Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хийгдсэн ажил үр дүнтэй байна уу	14-16
Дүгнэлт .....	17-18
Зөвлөмж .....	19-20

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- ОНӨААТҮГ- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
- ИТХ-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- АДБОУС- Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
- ААНБ- Аж ахуйн нэгж байгууллага
- СӨХ-Сууц өмчлөгчдийн холбоо
- ОНХС- Орон нутгийн хөгжлийн сан
- НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл
- ТУЗ-Төлөөлөн Удирдах Зөвлөл
- УИХ- Улсын Их Хурал
- НББ-Нягтлан Бодох Бүртгэл
- ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- БОГ Байгаль орчны газар